

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/02

Өлгий

Г Дархлаажуулалтын нэмэлт
тунд хамруулах тухай Г

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.14, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 07 ны өдрийн А\01 дүгээр тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын болон гадаадын 18-аас дээш насны иргэнийг сайн дурын үндсэн дээр коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины 4 дүгээр тунгаар вакцинжуулах ажлыг 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины дархлаа сэргээх нэмэлт, гурван тунд хамрагдсан, гурав дахь тунг тарьснаас хойш гурван сар өнгөрсөн болон вакцины үйлдвэрлэгчийн зааварт заасан хугацааг баримтлан шалгуурт нийцэх иргэнийг коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг Пфайзер-БиоНТех үйлдвэрийн "Комирнэти", Синофарм/BBIP үйлдвэрийн "CorV" вакцинаас сонголт хийлгэн, дархлаа сэргээх тунгаар вакцинжуулсугай.

3. Дархлаа сэргээх нэмэлт нэг тунгаар вакцинжуулахад шаардагдах Пфайзер-БиоНТех үйлдвэрийн "Комирнэти", Синофарм/BBIP үйлдвэрийн "CorV" вакцин, тариур, дагалдах хэрэгсэлийг аймаг, сумын Эрүүл, эрүүл мэндийн байгууллагын хэрэгцээ, захиалгад үндэслэн хуваарилах, түгээх үйл ажиллагааг зохион байгуулахыг Дархлаажуулалтын асуудал хариуцсан их эмч /А.Ерганат/-д үүрэг болгосугай.

4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины нэмэлт тунгаар вакцинжуулах арга хэмжээг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Нийгмийн Эрүүл Мэндийн төвийн дарга /Е.Сауле/ вакцинжуулалтын үйл ажиллагааг зохион байгуулж, цэгийн тоог нэмэгдүүлэх, дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг бүртгэх, мэдээлэх, тандах

5. Дархлаажуулалтын цахим бүртгэлийн програмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Мэдээлэл, технологи, телемедициний асуудал хариуцсан мэргэжилтэн /М.Еркебулан/-д үүрэг болгосугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга /Ш.Иманхан/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Н.САКЕН

